



Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2023 оны ... дугаар сарын ... –ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрх үүргийн хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. Хамрах хүрээ

Ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргийн хэрэгжилт, Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, даатгуулагч, ажил олгогчийн шимтгэл төлөлт, тоон болон цахим гарын үсгээр ирүүлсэн тайлан, шимтгэл төлөлтийн тооцоо, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг шалган баталгаажуулах харилцаа хамаарна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газар, Хяналт шалгалтын газар.

ТАВ. Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтийг хянах

5.1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагчийг бүртгэж, шимтгэл төлөгчийн дугаар олгосон байдал, хувийн хэрэг, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, сайн дураар даатгуулах гэрээ, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтын удирдамж, тайлан, мэдэгдэл, акт, албан шаардлага, шийтгэлийн хуудас болон холбогдох бусад баримт бичгийг шалгах.

5.2.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагчийн тоон гарын үсгээр болон цахимаар илгээсэн тухайн сарын тайлангийн даатгуулагчийн тоо, нийт цалингийн сан нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тохирч байгаа эсэхийг шалгах.

5.3.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч нар шимтгэлийн тайланд даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэл төлөлтийн төрлийг тодорхойлохдоо Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/ 21 дүгээр зүйл заалтыг зөв хэрэгжүүлсэн эсэхийг шалгах.

5.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч нар хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлөх төрлийн кодоос хамаарч ажил олгогч, даатгуулагчаас ногдуулсан шимтгэлийн дүн зөв тохирч байгаа эсэхийг шалгах.

5.5.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч ҮОМШӨ-ний даатгалын хувь хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага, эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар нийгмийн даатгалын шимтгэлийг хувь хэмжээг тогтоосон байдлыг шалгах.

5.6.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагчийн тайлант ээлжийн амралтын цалинг аль сард олгох орлогыг болохыг зөв тодорхойлсон эсэхийг шалгах.

5.7.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч нар тухайн даатгуулагчийн ажил мэргэжил, албан тушаалаар тогтоосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур тогтоосон эсэхийг шалгах.

5.8.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч нь хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцож тухайн сардаа багтаан нийгмийн даатгалын санд төлсөн эсэхийг шалгах.

5.9.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор цахим эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулж, харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад ирүүлсэн байдлыг шалгах.

5.9.1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч тоон болон цахим гарын үсгээр илгээсэн тайланг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд үнэн зөв бүртгэсэн байдлыг шалгах.

5.9.2.Сайн дурын даатгуулагч тоон гарын үсгээр болон цахимаар төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд үнэн зөв бүртгэсэн байдлыг шалгах.

5.10.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагчийн тоон болон цахим гарын үсгээр баталгаажсан тайлангийн өр, авлагын үлдэгдэл мэдээллийн нэгдсэн сантай тохирч байгаа эсэхийг шалгах.

5.11.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагчийн тоон болон цахим гарын үсгээр баталгаажуулж илгээсэн тайланд залруулга хийсэн байдлыг шалгах,

Санамж¹: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн залруулга гэдэгт нийгмийн даатгалын цахим мэдээллийн санд баталгаажсан тайлант засвар хийх, цалин өөрчлөх, даатгуулагчийн төрлийн код солих зэргийг хамааруулна.

5.12.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч хугацаа хоцроосон тайлан, хугацаандаа төлөөгүй шимтгэлд Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хуулийн хариуцлага хүлээлгэсэн байдлыг шалгах.

5.13.Ажил олгогч, даатгуулагч, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн баталгаажсан тайлангийн эцсийн үлдэгдлийг баталгаажсан байдлыг шалгах;

ЗУРГАА. Хариуцлага

6.1.Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүргийн бусад байгууллага хяналт тавина.

6.2.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Төрийн албаны болон Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛОО. Хэрэгжүүлэх хугацаа

7.1.Энэхүү журмыг 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллана.

---oOo---